

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ЦАХИМ ХАРИЛЦААНЫ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрээр эрхлэн явуулах, төрийн мэдээллийн сангийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд ашиглуулах, харилцан мэдээлэл солилцох, тэдгээрийн аюулгүй байдлыг хангахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн цахим харилцааны хууль тогтоомж

2.1.Төрийн цахим харилцааны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Харилцаа холбооны тухай хууль, Архивын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн бүх шатны байгууллага, иргэн, хуулийн этгээдэд үйлчилнэ.

3.2.Үйлчилгээ, үйл ажиллагааг цаасан хэлбэрээр гүйцэтгэхээр хуулиар тусгайлан зохицуулсан бол энэ хууль үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“цахим харилцаа” мэдээллийн технологи ашиглан төрийн байгууллага хооронд цахим хэлбэрээр харилцах, цахим баримт бичиг солилцох, төрийн байгууллага болон иргэн, хуулийн этгээд хооронд цахим хэлбэрээр харилцах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

4.1.2.“мэдээллийн систем” гэж гэж цахим өгөгдөл, мэдээлэл, цахим баримт бичгийг үүсгэх, илгээх, хүлээн авах, хадгалах болон боловсруулах системийг;

4.1.3. “мэдээллийн сан” гэж төрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үүсч бий болсон хайлт, боловсруулалт хийх, мэдээлэл гаргах бололцоотой, бүтэцлэгдсэн цахим өгөгдлийн бүрдлийг;

4.1.4. “цахим баримт бичиг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.4-т заасныг;

4.1.5. “төрийн нээлттэй өгөгдөл” гэж төрийн байгууллагын мэдээллийн сангийн мэдээллийг хувь хүний, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл агуулаагүй байдлаар, нээлттэйгээр ашиглах, чөлөөтэй хандах, дахин боловсруулах, түгээхэд зориулж машинд уншигдах хэлбэрт бэлтгэснийг;

4.1.6. “иргэнийг тодорхойлох цахим өгөгдөл” гэж төрийн болон хуулийн этгээдээс үйлчлүүлэгчээ адилтган таних зорилгоор олгосон, эсвэл үйлчлүүлэгч өөрөө үүсгэж бүртгүүлсэн цахим өгөгдөл (ID), эсвэл үйлчлүүлэгчийн нэр дээр бүртгэлтэй телефон утасны дугаар;

5 дугаар зүйл. Цахим харилцаанд баримтлах зарчим

5.1. Цахим харилцаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. цахим харилцаа нь харилцан уялдаатай, технологийн хувьд нэгдмэл байх;

5.1.3. төр, иргэн, хуулийн этгээдийн өгөгдөл, цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;

5.1.4. төрийн цахим харилцаанд иргэн, хуулийн этгээдийн тэгш оролцоог хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ЦАХИМ ХАРИЛЦАА

6 дугаар зүйл. Төрийн цахим харилцааны дэд бүтэц

6.1. Төрийн цахим харилцааны дэд бүтэц нь төрийн байгууллагын мэдээллийн систем, төрийн байгууллагын мэдээллийн сан, мэдээллийн сүлжээ, төрийн цахим харилцааны суурь системээс бүрдэнэ.

6.2. Төрийн цахим харилцааны суурь систем нь төрийн мэдээлэл солилцооны систем, таних баталгаажуулах систем, цахим албан хэрэг хөтлөлтийн систем, эргэн мэдээлэх систем, албаны цахим шуудан, төрийн үйлчилгээний порталаас бүрдэнэ.

7 дугаар зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн систем

7.1. Төрийн байгууллагын мэдээллийн систем нь тухайн байгууллагын хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааг дэмжих систем байна.

7.2.Мэдээллийн систем нь төрийн цахим харилцаа, суурь системд ашиглах технологи, инновацийн талаар баримтлах чиглэл, төрийн цахим харилцааны ерөнхий архитектур, мэдээллийн аюулгүй байдлын стандартад нийцсэн байна.

7.3.Төрийн байгууллага нь мэдээллийн системийн ашиглалт, үйлчилгээ, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах журам, заавартай байна.

7.4.Төрийн байгууллага энэ хуулийн 6.2-д заасан суурь системийг ашиглахдаа энэ хуулийн 20.3.3–д заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

8 дугаар зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн сан

8.1.Төрийн байгууллагын хууль, тогтоомжоор тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд мэдээллийн сан үүсэх ба анхдагч эх үүсвэр байна.

8.2.Төрийн байгууллага нь мэдээллийн санг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, баталгаажуулна.

8.3. Төрийн байгууллага мэдээллийн санг цахим хэлбэрээр болон цаасан суурьтай мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх замаар үүсгэнэ.

8.4.Мэдээллийн сан нь дараах төрөлтэй байна.

8.4.1.суурь мэдээллийн сан

8.4.2.төрөлжсөн мэдээллийн сан

8.4.3.байгууллагын мэдээллийн сан

8.5.Мэдээллийн санг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хамтран баталсан нэгдсэн ангилал, кодын дагуу бүрдүүлнэ.

8.6.Суурь мэдээллийн санд Улсын бүртгэлтийн ерөнхий хуулийн 6, 7, 8-д заасан, Геодези, зураг зүйн тухай хуулийн 9-д заасан мэдээллийн сан хамаарна.

8.7.Төрөлжсөн мэдээллийн санд төрийн байгууллагын хууль, тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн дагуу үүсгэсэн энэ хуулийн 8.4.1, 8.4.3-т зааснаас бусад мэдээллийн сан хамаарна.

8.8.Байгууллагын мэдээллийн санд Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7, 8, 9, 10-д заасан цахим мэдээллээс бүрдсэн мэдээллийн сан, дотоод үйл ажиллагааны явцад үүссэн мэдээллийн сан хамаарна.

8.9.Төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээлэл нь суурь мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэнэ.

8.10.Төрийн байгууллага чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд үүссэн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцна.

8.11.Байгууллагын болон төрөлжсөн мэдээллийн сангийн нөөцийг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан байгууллагад хадгалж болно.

9 дүгээр зүйл. Төрийн мэдээллийн сангийн ашиглалт

9.1.Иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрснөөр, эсвэл төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулаагүй мэдээллийн санг дараах зорилгоор ашиглана:

9.1.1.иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх;

9.1.2.УИХ, ЕТГ, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага бодлого боловсруулах;

9.1.3.эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;

9.1.4.төрийн нээлттэй өгөгдөл бий болгох;

9.1.5.цахим архив үүсгэх;

9.1.6.хуульд заасан бусад.

9.2.Иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг Засгийн газраас батална.

9.3.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2-д заасан зорилгоор төрийн мэдээлэл ашиглах хүсэлтийг харилцаа холбоо, мэдээлэл технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

9.4.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хянаж төрийн цахим мэдээлэл солилцооны системд хандах хандалтын эрхийг тогтооно.

9.5.Энэ хуулийн 9.4–д заасныг үндэслэн Үндэсний дата төв УТҮГ төрийн цахим мэдээлэл солилцооны системээр мэдээлэл солилцох холболт үүсгэнэ.

9.6.Энэ хуулийн 9.1.3, 9.1.4–д заасан харилцааг Засгийн газраас баталсан журмаар тус тус зохицуулна.

9.7.төрийн нээлттэй өгөгдлийг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан байгууллагаас хөгжүүлсэн төрийн нээлттэй өгөгдлийн порталд нийтэлнэ.

9.8.энэ хуулийн 9.1.5-д заасан цахим архив үүсгэх харилцааг Архивын тухай хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл. Төрийн цахим мэдээлэл солилцооны систем

10.1.Төрийн цахим мэдээлэл солилцох систем нь бусад мэдээллийн систем, мэдээллийн сантай холбогдон ажиллах чадвартай, нийтийн түлхүүрийн дэд бүтэцтэй холбогдсон, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байна.

10.2.Төрийн байгууллага өөр хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо төрийн цахим мэдээлэл солилцооны системийг ашиглана.

10.3.Төрийн цахим мэдээлэл солилцооны систем нь төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл солилцох тэгш боломжийг олгоно.

10.4.Цахим мэдээлэл солилцохтой холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.

11 дүгээр зүйл. Таних, баталгаажуулах систем

11.1.Цахим хэлбэрээр үйлчилгээ авах хүсэлт гаргасан иргэнийг танилт, баталгаажуулалт хийнэ.

11.2.Цахим харилцаанд оролцогч этгээдийг танихтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.

11.3.Танилт хийхэд цахим гарын үсэг, иргэний биеийн давхцахгүй өгөгдөл, иргэнийг тодорхойлох цахим өгөгдөл ашиглаж болно.

11.4.Баталгаажуулалт хийхэд тоон гарын үсэг эсхүл энэ хуулийн 8.1.4-д заасан суурь мэдээллийн сангийн мэдээлэл, төрийн байгууллага болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглана.

12 дугаар зүйл. Албан хэрэг хөтлөлтийн систем

12.1.Төрийн байгууллага төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад цахим баримт бичгийг зохион бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, явуулах, дамжуулах, солилцох, шийдвэрлэлтэд хяналт тавих, мэдээ тайлан гаргах, цахим баримт бичгийг ангилан төрөлжүүлэх, албан хэрэг бүрдүүлэх, хадгалахад албан хэрэг хөтлөлтийн систем ашиглана.

12.2.Цахим баримт бичгийн эх баримт нь дараах хоёр төрөлтэй байна:

12.2.1.цаасан суурьтай баримт бичгээс үүссэн цахим баримт бичгийн хувьд цаасан хувь нь;

12.2.2.цахим хэлбэрээр зохион бүрдүүлсэн баримт бичгийн хувьд дараах шаардлагыг хангасан цахим баримт бичиг:

12.2.2.1.цахим баримт бичгийг үүсгэсэн этгээдийг тодорхойлох боломжтой байх;

12.2.2.2.цахим баримт бичгийн мэдээлэл өөрчлөгдөөгүйг тогтоох боломжтой арга хэрэглэсэн байх;

12.4.Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөхтэй холбогдсон харилцааг Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.4–д заасан журмаар зохицуулна.

13 дугаар зүйл.Албаны цахим шуудан

13.1.Төрийн байгууллага, албан тушаалтан нь цахим хэлбэрээр харилцахдаа албаны цахим шууданг ашиглана.

13.2.Албаны цахим шуудангийн системийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байршуулна.

14 дүгээр зүйл.Эргэн мэдээлэх систем

14.1.Төрийн байгууллага иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр мэдэгдэл (notification) хүргэж болно.

14.2.Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдэгдэл (notification) хүлээн авахыг зөвшөөрсөн бол дараах тохиолдолд хүргэнэ:

14.2.1.иргэн, хуулийн этгээдийн цахим мэдээлэлд хуулиар эрх олгогдоогүй байгууллага, албан тушаалтан хандсан;

14.2.2.төрийн байгууллагад хандан гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, үр дүн.

14.4.Хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн байгууллагаас зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдэгдэл хүргэхэд энэ хуулийн 14.2 дахь хэсэг хамаарахгүй.

14.5.Эргэн мэдээлэх системийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ашиглана.

15 дугаар зүйл.Төрийн үйлчилгээний портал

15.1.Төрийн үйлчилгээний портал нь хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх хэрэгсэл байна.

15.2.Төрийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний порталд нэгтгэнэ.

15.3.Төрийн үйлчилгээний порталыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ашиглана.

16 дугаар зүйл.Олон нийтийн оролцооны систем

16.1.Олон нийтийн оролцооны систем нь төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэн өөрийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр ирүүлэх, төрийн үйлчилгээнд үнэлгээ өгөх, төрийн байгууллагаас зохион байгуулж байгаа санал асуулга, судалгаанд оролцох боломжийг бүрдүүлнэ.

16.2.Энэ хуулийн 16.1-т заасан системийн үйл ажиллагаанд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу хяналт тавьж, хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ЦАХИМ ХАРИЛЦААНЫ ТОГТОЛЦОО

17 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

17.1.Засгийн газар төрийн цахим харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний жагсаалтыг батлах;

17.1.2.төрийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, солилцох журам батлах;

17.1.3.цахим харилцаанд оролцогч этгээдийг таних журмыг батлах;

17.1.4.төрийн мэдээллийн санг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зорилгоор ашиглах нийтлэг журам батлах;

17.1.5.төрийн нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх, нийтлэх журам батлах;

17.1.6.төрийн цахим харилцааны хүний нөөц, иргэдийн цахим боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр батлах.

18 дугаар зүйл. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

18.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн цахим харилцааны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.төрийн цахим харилцааны талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангах;

18.1.2.төрийн цахим харилцаа, баримтлах чиглэлд хамаарах дүрэм, журам, заавар, удирдамж батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.3.энэ хуулийн 17.1.1-17.1.6-д заасан хөтөлбөр, журам, жагсаалт боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, үнэлгээ хийх;

18.1.4.төрийн цахим харилцаа, суурь системд ашиглах технологи, инновацийн талаар баримтлах чиглэл батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.5.төрийн цахим харилцааны ерөнхий архитектурыг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.6.төрийн байгууллагаас хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн цахим харилцааны хэсэг, тэдгээрийн технологийн шийдэл нь энэ хуулийн 18.1.4, 18.1.5-д нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

18.1.7.энэ хуулийн 8.2–д заасан бүртгэл хөтлөх, баталгаажуулалт хийх;

18.1.8.төрийн цахим харилцааны суурь системийн техникийн нөхцөл, шаардлагыг батлах;

18.1.9.төрийн нээлттэй өгөгдлийн жагсаалт батлах;

18.1.10.Үндэсний дата төвийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

18.1.11.төрийн байгууллагын цахим харилцаа хариуцсан нэгж, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

18.1.12.гадаад орны болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

19 дүгээр зүйл.Төрийн байгууллагын чиг үүрэг

19.1.Энэ хууль болон бусад хуулиар тогтоосон хэм хэмжээ, энэ хуулийн 17.1.1-д заасан жагсаалтад нийцүүлэн салбарын болон байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, инноваци нэвтрүүлэх;

19.2.Мэдээллийн систем, мэдээллийн сан, түүхчилсэн бүртгэл (log)-ийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

19.3.Энэ хуулийн 7.3-т заасан журам, зааврыг баталж мөрдөх;

19.4.Энэ хуулийн 9.1-д заасны дагуу мэдээллийн санг цахим хэлбэрээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

19.5.Энэ хуулийн 20.3.3-д заасан техникийн нөхцөл, шаардлагыг хангаж төрийн цахим харилцааны суурь системд холбох;

19.6.Нээлттэй өгөгдлийг мэдээллийн системд уншигдах хэлбэрээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд ашиглах боломжийг бүрдүүлэх, төрийн нээлттэй өгөгдлийн порталд нийтлэх;

19.7.Цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээг төрийн үйлчилгээний порталд холбох;

19.8.Мэдээллийн сан, түүний шинэчлэлт, өөрчлөлтийг энэ хуулийн 8.2-д заасны дагуу бүртгүүлэх;

19.9.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл нь төрийн цахим харилцаанд хамаарах төсөл, арга хэмжээний санал агуулсан бол жил бүрийн 01 дүгээр сарын 20-ноос өмнө Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулах.

19.10.Мэдээллийн технологийн аудитыг Харилцаа холбооны тухай хуулийн 30.¹ дүгээр зүйлд заасны дагуу хийлгэх;

19.11.Цахим мэдээллийн аюулгүй байдал, төрийн цахим харилцааны зардлыг байгууллагын мэдээллийн систем, сан, сүлжээний тасралтгүй ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, албан хаагчдыг чадавхижуулахад зарцуулах.

20 дугаар зүйл. Үндэсний дата төвийн чиг үүрэг

20.1.Төрийн цахим харилцаа, үйлчилгээний дэд бүтэц, суурь системийн хөгжүүлэлт, тогтвортой ажиллагаа, төрийн мэдээллийн сангийн хадгалалт, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг Үндэсний дата төв хариуцна.

20.2.Үндэсний дата төв нь улсын төсөвт үйлдвэрийн газар байна.

20.3. Үндэсний дата төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.3.1.төрийн цахим мэдээллийн санг стандартын шаардлага хангасан нөхцөлд хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах;

20.3.2. төрийн цахим харилцааны суурь системийн хөгжүүлэлт, ашиглалт, үйлчилгээ, тогтвортой ажиллагааг хангах;

20.3.3.төрийн цахим харилцааны суурь системийг ашиглах хуулийн этгээдийн мэдээллийн системд тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлох;

20.3.4. төрийн цахим харилцааны суурь системийн түүхчилсэн бичлэг /лог/ үүсгэх, хадгалах, хамгаалах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;

20.3.5.төрийн байгууллагад мэдээллийн технологи, өгөгдлийн боловсруулалтын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, сургалт явуулах;

20.3.6.төрийн нээлттэй өгөгдлийн порталыг хөгжүүлэх, ашиглалт, үйлчилгээг хариуцах;

20.3.7.иргэн, хуулийн этгээдэд энэ хуулийн 18.1.11-д заасан стратеги үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан үйлчилгээ үзүүлэх;

21 дүгээр зүйл.Төрийн цахим харилцааны талаар иргэн, хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг

21.1.Төрийн цахим харилцаанд иргэн, хуулийн этгээд дараахь эрхтэй:

21.1.1.төрийн цахим мэдээллийн сан дахь өөрийн өгөгдөл, мэдээлэлтэй танилцах, хамгаалуулах;

21.1.2.энэ хуулийн 14.2-т заасан эргэн мэдээлэх үйлчилгээг сонгох, бүхэлд нь эсвэл хэсэгчлэн татгалзах, үйлчилгээ авах хэлбэрээ сонгох;

21.2.Төрийн цахим харилцаанд иргэн, хуулийн этгээд дараахь үүрэгтэй:
21.2.1.цахим үйлчилгээний системд ашигладаг нууц үг, бусад хамгаалалтын арга, хэрэгслийн нууцлалыг бусдад задруулахгүй байх;

21.2.2.төрийн цахим үйлчилгээний систем, иргэний нууцалсан буюу хамгаалагдсан систем, мэдээлэлд халдахгүй, доголдол үүсгэхгүй байх;

21.2.3.тоон гарын үсгийн гэрчилгээ, түүний тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

22 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

22.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

22.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

23 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

23.1.Энэ хуулийг 2020 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг